

ЛИФТНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 10 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Нэг. Техникийн үзүүлэлт

- Нийтийн зориулалттай орон сууцны барилгын хүн зөөврийн лифт нь Олон улсын ISO 14001, Европын 2014/33/EU, EN 81-20:2014 стандартын шаардлага хангасан эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй байна.
- EN 81-20-2014 стандартын чанарын шаардлагатай дүйцэх лифт нийлүүлэх;
- Шинэчлэлт хийхээр төлөвлөсөн ажлын объектод сууринуулах лифт нь олон улсын ISO 4190-01 стандартын шаардлага хангасан байна. Үүнд:
 - Ачаа даах чадвар 12 давхарт 400 кг-аас багагүй;
 - Орчин үеийн синхрон мотортой;
 - Хурд – 0.71– 1 м/с-ээс багагүй;
 - Бүхээгийн өндөр – 2.0– 2.5 м;
 - Бүхээгийн хаалганы өндөр – 2– 2.1 м;
 - Худгийн гүн – 1.1– 1.7 м;
 - Хаалга – 2 тийш онгойдог;
 - Хаалга хаагдах үед ямар нэг саад байхад хаагдахгүй байх мэдрэгчтэй;
 - Өргөх өндөр – 36.5-44.4 м (12 давхар барилгад)
 - 12 давхар байр 12 зогсоолтой 1 ш лифт;
 - Лифтний хүчдэл тасрах, гацахад хамгийн ойр давхарт хүнээ буулгах UPS тог баригчтай ARD (AUTO RESCUE DEVICE) аврах төхөөрөмжтэй байх;
 - Бүхээгийн дээд оройгоос хонгилын дээд хучилтын хийцийн хамгийн доод цэг хүртэлх зайд 1м-ээс багагүй байна. (ЛТААД-ийн 3.18)
 - Лифтний бүхээгт давхар заагч электрон дэлгэцтэй байх;
 - Үйлдвэрээс нийлүүлэгдэж буй лифтний эд ангийн туршсан акт, сертификаттай байх (даацын троос, хурд хязгаарлагч, ерөнхий программ хангамж, ерөнхий мотор сертификат)
- 1. Лифтний зам төмрийг заавал сольж тавих.
- 2. Шинээр нийлүүлж угсралдах лифт нь тавьсан шаардлагад нийцсэн, шинэ ба ашиглагдаагүй, сүүлийн үеийн техникийн дэвшилттэй, цахилгаан эрчим хүчний хэлбэлзлээс хамгаалагдсан, эрчим хүчийг 30 хувиас багагүй хэмнэх нөхцөлийг хангасан байна.
- 3. Лифтний угсралтын ажлыг гүйцэтгэхдээ ЗТБХБ сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийг баримтална.
- 4. Лифтийг угсралсны дараа ашиглалтад өгөхийн өмнө туршилтын ажлыг явуулахдаа захиалагч, ашиглалтын байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагуудын төлөөлөгчдийг байлцуулан гүйцэтгэнэ.
- 5. Лифтийг угсрал үе шатны ажил (лифтний зам төмөр, хөтлүүрийн суурь, хонгилын хаалга гэх мэт) эхлэх дуусах бүрд захиалагч байгууллагыг байлцуулан шалгуулж шаардлага хангасан тухай акт үйлдээний дараа цаашид хийх ажлыг үргэлжлүүлнэ.
- 6. Лифтийг ажлын талбай дээр буулгаж хуучин лифт буулгах шинэ лифт угсралын өмнө тус ажлуудыг заавал захиалагчид мэдэгдэнэ.
- 7. Лифтний хонгилын хэсгийн барилгын үндсэн хийц эдлэлд өөрчлөлт оруулах, хучилтын хавтанд нэмэлт ачаалал өгөх, угсрал зорилгоор эвдэж гэмтээхийг хориглоно.
- 8. Зорчигчийн бүхээг болон жижүүрийн өрөө, машины өрөөний хооронд холбогдох телефон холбоотой байна.
- 9. Байрны давхар бүрд явах чиглэлийг заасан гэрэлтэй кнопк, лифтний байршил заасан электрон дэлгэцтэй байна.

10. Лифтний хонгилын хаалганы гулсагчид (башмак) нэмэлтээр үйлдвэрийн хамгаалалтын тоноглол суурилуулсан байна.

Хоёр. Ажлын тоо хэмжээ

Ажлын тоо хэмжээнд тусгагдсан ажлуудын төсөвт өртийг багц тус бүрээр ирүүлэх бөгөөд төсвийн тооцоонд цалин, материал, /материалын зардалд тоног төхөөрөмжийн үнийг оруулж тооцно. Тоног төхөөрөмжийн үнэнд гаалийн татвар хураамж орсон байна/ механизмын тээврийн зардлуудыг тооцож ирүүлэх ба нэмэгдэл дайвар зардлууд, нормчлохын сан 0.18%, нэмэгдсэн өртийн албан татвар 10%, магадалшгүй ажлын зардал 2%, захиалагчийн хяналтын зардал 2% төсөв зохиох зааврын дагуу оруулж тооцсон байх шаардлагатай. Давхруудын хонгилын хаалганы амлагаа хийх, техникийн өрөөний засал хийх зардлыг төсөвт тусгана. (Эдгээр зардлуудыг тоног төхөөрөмжийн үнэ орсон дунгээс тооцно)

2.1 Лифтний угсралтын ажил 12 давхар (12 зогсоолтой)

Д/д	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	400 кг-аас багагүй даацтай лифт, зогсоолын тоо 12, хонгилын өндөр 36.5-44.4 м, бүхээгийн хурд 0.71-1 м/с багагүй	ком	1
2	Лифтний тэжээлийн самбар угсрах	ком	1
3	Хурд хязгаарлагч угсрах	ком	1
4	Лифтний хаалга угсрах	ш	12
5	Лифтний зам төмөр буулгах, угсрах	тн	2,6
6	Хөдөлгүүр угсрах	ком	1

Эдгээр ажилтай уядан гарах нэмэгдэл ажлын зардлыг /лифтнүүдийг газардуулгатай холбох, газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлэх, туршилт тохируулга хийх/ гүйцэтгэгч хариуцах ба буулгасан лифтнүүдийг хариуцсан холбогдох байгууллагад хүлээлгэн өгнө.

Гурав. Ажлын талбай

д/д	СӨХ-ны нэр	Дүүрэг, хороо	Байр, орц	Лифтний тоо	Зогсоолын тоо
1	Тулга-3 СӨХ	БЗД, 3-р хороо Нийт	4А-р байр	1 1	12

Дөрөв. Ажлын зохион байгуулалт

1. Гүйцэтгэгч дараах зүйлийг ажлын төлөвлөгөөнд тусгаж захиалагчид ирүүлнэ. Үүнд:

- Гүйцэтгэх ажлын нарийвчилсан график;
- Ажлын талбайг бэлтгэх;
- Бараа нийлүүлэх график;
- Ажлын талбай дээр барааг буулгах;
- Хуучин цахилгаан шатыг буулгах;
- Шинэ цахилгаан шатыг шинээр угсрах;
- Давхруудын хонгилын хаалганы амлагаа болон техникийн өрөөний засал хийх
- Үйлчилгээтэй (нийлүүлэгчийн хэрэгжүүлэх тээвэрлэлт, даатгал болон техникийн туслалцаа, сургалт зэрэг аливаа дагалдах ажил) холбоотой ажлын хуваарь;

2. Гүйцэтгэгч байгууллага нийлүүлэх барааны тодорхойлолт, техникийн шаардлага, түүнийг дагалдах болон ашиглалтын явцад хэрэглэгдэх хэмжих хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж зэргийг Монгол хэл дээр буулгаж захиалагчид өгнө.

3. Техникийн паспортад ажлын зураг, схем, гагнуур, суурь, далд ажил, газардуулгын зэрэг актуудыг бүрдүүлж, монгол хэл дээр буулгаж лифт ашиглагч байгууллагад хүлээлгэж өгнө.
4. Лифтэнд тохиргоо хийх гар удирдлага буюу мини консулыг дагалдуулж өгнө.
5. Улс, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажил үйлчилгээг Нийслэлийн өмчид бүртгүүлж НӨХГ-т хүлээлгэн өгнө.
6. Лифтийг нийлүүлэн угсралтад байгууллага ажил эхлэх зөвшөөрлийг бараа нийлүүлэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор авсан байна.

- Угсарсан шинэ лифтний туршилт тохируулгатай холбогдон гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан авах зөвшөөрлийн асуудлыг нийлүүлэгч буюу гүйцэтгэгч хариуцна.
- Нийлүүлэгч ўе шатны ажил дууссан нөхцөл бүрд мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөгчийг байлцуулан угсралтын байдлыг шалгаж, техникийн магадлал хийж баталгаажуулан ашиглах зөвшөөрел авна.
- Ажлыг гүйцэтгэхэд дагаж мөрдөх норм, дүрмийн дагуу гүйцэтгэнэ.

7. Орон сууцны барилгын лифтийг шинээр угсарсны (шинэчлэлт хийгдсэний) дараа ашиглалтад оруулахын өмнө техникийн бүрэн туршилтыг захиалагч, гүйцэтгэгч байгууллага, хяналтын байгууллагатай хамтран хийж техникийн дүгнэлт гаргуулна. Туршилт тохируулгын зардлыг гүйцэтгэгч хариуцна.

8. Баталгаат хугацаанд ашиглагчийг шаардлагатай сэлбэг хэрэгслээр тасралтгүй хангах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Мөн цаашид шаардлагатай сэлбэг хэрэгслээр ханган ажиллана.

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Ц.УРАНБИЛЭГ



БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Л.АНГАРАГ